



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА

Сайншанд 2020 он

Мэргэжлийн зөвлөгөө өгсөн:

Д.Нармандах Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн Үндэсний зөвлөх

Судалгааны дүнг боловсруулж, тайлан бэлтгэсэн:

Ч.Наранбилэг Улаангом политехник коллежийн сургалтын арга зүйч, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн зөвлөх багш

Г.Эрдэнэмөнх Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, хөдөлмөрийн зах зээлийн судалгааны багийн ахлагч

Хянан тохиолдуулсан:

Т.Энхтуяа Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн захирал

Д.Цэндмаа Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:

Ч.Наранбилэг Улаангом политехник коллежийн сургалтын арга зүйч, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн зөвлөх багш

Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн санхүүжилтээр хэвлүүлэв.

Энэхүү тайланг зөвшөөрөлгүйгээр олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.

..... хэвлэх үйлдвэрт хэвлэв.

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	7
ХӨДӨЛМӨРИЙН НЭР ТОМЬЁОНЫ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	8
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	
1.1. Судалгааны танилцуулга	12
1.2. Судалгааны түүвэр, хамрах хүрээ	
1.3. Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт	
БҮЛЭГ 2. ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	
2.1. Хүн ам	15
2.2. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд	
2.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдал	
2.4 Ажил олгогчид	
БҮЛЭГ 3. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН	
3.1. Аж ахуйн нэгж, байгууллагуудаас авсан тоон судалгааны дүн	
3.2. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс авсан тоон судалгааны дүн	
3.3. Малчдаас авсан судалгааны дүн	
3.4. Ажилгүй иргэдээс авсан судалгааны дүн	
3.5. Ажиллаж байгаа залуучуудаас авсан судалгааны дүн	
3.6. Хөдөлмөрийн зах зээлийн чанарын судалгааны дүн	
3.7. Дорноговь аймагт улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болох ажлын байрны судалгаа	
БҮЛЭГ 4. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГААНЫ ДҮН	
4.1. Их, дээд сургуульд суралцагчдын судалгааны дүн	
4.2. Дорноговь аймаг дахь мэргэжлийн сургуулиудын нийлүүлэлт	
БҮЛЭГ 5. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТЭНЦЭЛ	
5.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцэл ба үл нийцэл	
ДҮГНЭЛТ	
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	
ХАВСРАЛТ	

ӨМНӨХ ҮГ

Дорноговь аймаг анх удаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлт судлах ажлыг 2015-2020 онд харьцуулан судалсан бусад аймгуудын туршлагад тулгуурлан, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр Германы “GFA” зөвлөх компанийн хэрэгжүүлж байгаа Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн санхүүгийн болон мэргэжлийн туслалцаатайгаар гүйцэтгэлээ.

Уг судалгааны ажлын үндсэн зорилго нь Дорноговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлтийг тодорхойлж, дүгнэлт зөвлөмж гарган, аймгийнхаа ирээдүйн хөгжлийн бодлого төлөвлөлтөнд ашиглах явдал юм.

Энэхүү судалгаагаар аймгийн хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны буюу 2021-2023 оны эрэлт, нийлүүлэлтийн тоо хэмжээ, гарч болох чанарын өөрчлөлтийн талаарх мэдээллийг нэгтгэж, дүгнэлт, зөвлөмж гарган, боловсрол, сургалтын болон хөдөлмөр эрхлэлтийн салбарын бодлого боловсруулагчид, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн мэдээллийн хэрэгцээнд нийлүүлж байна.

Шаардагдах мэргэжил бүрээр гаргасан орон нутгийн хөдөлмөрийн зах зээл дэх эрэлтийн тухай мэдээллийг аймгийн боловсрол, хөдөлмөрийн салбар, сургалтын байгууллагууд ажиллах хүч бэлтгэх бодлого боловсруулахдаа, хувь хүн мэргэжлээ сонгохдоо харгалзан үзэх боломж бүрдэж байгаагаараа чухал ач холбогдолтой боллоо.

Түүнчлэн аймгийн боловсрол, сургалтын байгууллагууд орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн чанарын судалгааны үр дүнд тулгуурлан, сургалтын хөтөлбөр, агуулгаа шинэчлэх, суралцагчдад шаардлагатай ур чадвар эзэмшүүлэх, хандлага төлөвшүүлэх зэрэг олон хэлбэрийн ажил зохион байгуулах боломжтой болно.

Судалгааны ажлыг амжилттай зохион байгуулсан аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын хамт олон, мэдээлэл цуглуулах ажлыг хурдан шуурхай гүйцэтгэсэн багийн гишүүд, судалгаанд оролцсон ажил олгогчид, иргэд, санхүүгийн дэмжлэг үзүүлж мэргэжлийн туслалцаа, зөвлөгөөгөөр хангасан Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн захирал Т.Энхтуяа, Төслийн Үндэсний зөвлөх Д.Нармандах, зөвлөх багш Ч.Наранбилэг нарт гүн талархал илэрхийлье.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗӨЛӨЛИЙН ДАРГА,
ЗАСАГ ДАРГА О. БАТЖАРГАЛ



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АУС	Анагаах ухааны сургууль
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МБ	Мэргэжлийн боловсрол
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ТБ	Техникийн боловсрол
ХДАТ	Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин
ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХЭ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.1	Хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр	16
Хүснэгт 2.2.1	Ажиллах хүчний оролцооны ба хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувиар	16
Хүснэгт 2.2.2	Ажиллах хүч ба ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, хүйс, хот, хөдөөгөөр	17
Хүснэгт 2.2.3	Ажиллах хүч ба ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, сумаар	17
Хүснэгт 2.2.4	Ажиллах хүч ба ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, эмэгтэй, сумаар	18
Хүснэгт 2.2.5	Ажил эрхлэгчдийн тоо, ажил мэргэжлийн ангиллаар	18
Хүснэгт 2.2.6	Ажил эрхлэгчдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	19
Хүснэгт 2.2.7	Ажил эрхлэгчдийн тоо, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар	20
Хүснэгт 2.3.1	Ажлын байрны захиалгын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	20
Хүснэгт 2.3.2	Ажлын байрны захиалгын тоо, ажил мэргэжлийн ангиллаар	21
Хүснэгт 2.3.3	Ажил хайгч иргэний тоо, боловсролын түвшингээр	22
Хүснэгт 2.3.4	Ажил хайгч иргэний тоо, сумаар	23
Хүснэгт 2.3.5	Ажилд зуучилсан иргэдийн тоо, ажил, мэргэжлийн ангиллаар	23
Хүснэгт 2.3.6	Шинэ ажлын байранд орсон иргэний тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2020 оны 1-9 сард	24
Хүснэгт 2.4.1	ААНБ-ын тоо, сум, үйл ажиллагаа эрхлэлтээр	25
Хүснэгт 2.4.2	Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, сум, хариуцлагын хэлбэрээр	25
Хүснэгт 2.4.3	Үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	26
Хүснэгт 2.4.4	Малчин өрх ба малчдын тоо, сум, насны бүлгээр	27
Хүснэгт 3.1.1	Судалгаанд хамрагдсан ААНБ-ын тоо, эзлэх хувь, хариуцлагын хэлбэрээр	28
Хүснэгт 3.1.2	Судалгаанд хамрагдсан ААНБ-ын тоо, эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	29
Хүснэгт 3.1.3	Өндөр насны тэтгэвэрт гарах ажилтны тоо	30
Хүснэгт 3.1.4	ААНБ-ын эрэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, мэргэжлээр	30
Хүснэгт 3.2.1	ХХЭ-дийн үйл ажиллагааны чиглэл, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	36
Хүснэгт 3.2.2	ХХЭ-дийн үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл	36
Хүснэгт 3.2.3	ХХЭ-дийн эрэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, мэргэжлээр	37
Хүснэгт 3.3.1	Туслах малчин авах өрхийн тоо	40
Хүснэгт 3.4.1	Ажилгүй иргэдийн мэргэжил, хүний тоогоор	41
Хүснэгт 3.4.2	Ажилгүй иргэдийн суралцахыг хүссэн мэргэжил, хүний тоогоор	44
Хүснэгт 3.5.1	Судалгаанд хамрагдсан ажиллаж буй залуучуудын тоо, сумаар	46
Хүснэгт 3.5.2	Ажиллаж буй залуучуудын эзэмшсэн мэргэжил, хүний тоогоор	46
Хүснэгт 3.5.3	Мэргэжлийн бус ажил хийж байгаа залуучуудын эзэмшсэн мэргэжил, хүний тоогоор	50
Хүснэгт 3.5.4	Ажиллаж байгаа залуучуудын суралцахыг хүссэн мэргэжил, хүний тоогоор	52
Хүснэгт 3.7.1	Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болох ажлын байрны тоо, оноор	57
Хүснэгт 4.1.1	Их, дээд сургуульд суралцаж буй оюутны тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, мэргэжлээр	65
Хүснэгт 4.1.2	АШУҮИС-ийн салбар Дорноговь аймаг дахь АУС-ийг төгсөгчдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, мэргэжлээр	69

Хүснэгт 4.1.3	Дорноговь аймаг дахь МСҮТ-ийг төгсөгчдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, мэргэжлээр	70
Хүснэгт 4.1.4	Дорноговь аймаг дахь Төмөр замын МСҮТ-ийг төгсөгчдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, мэргэжлээр	70
Хүснэгт 5.1.1	Дорноговь аймгийн 2021-2023 оны эрэлт, нийлүүлэлтийн тэнцэл, үл нийцэл	71
Хүснэгт 5.1.2	Хамгийн их эрэлттэй мэргэжлүүдийн эрэлт, нийлүүлэлтийн харьцаа	87
Хүснэгт 5.1.3	Хамгийн их нийлүүлэлттэй мэргэжлүүдийн нийлүүлэлт, эрэлтийн харьцаа	88

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.1	Хүн амын нас, хүйсийн суварга	16
Зураг 2.1.2	Хүн амын тоо, насны бүтцээр	16
Зураг 2.3.1	Ажлын байрны захиалгын тоо, өмчийн хэлбэрээр	21
Зураг 2.3.2	Ажлын байрны захиалгын тоо, хариуцлагын хэлбэрээр	21
Зураг 2.3.3	Ажил хайгч иргэний тоо, боловсролын түвшин, хувиар	22
Зураг 2.4.1	Үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын ажиллагчдын тооны бүлэг, хувиар	26
Зураг 2.4.2	Малчин өрхийн тоо, малын тооны бүлэглэлтээр	27
Зураг 3.1.1	Судалгаанд хамрагдсан ААНБ-ын тоо, сумаар	28
Зураг 3.1.2	Судалгаанд хамрагдсан ААНБ-ын тоо, ажиллагчдын тооны бүлгээр	30
Зураг 3.1.3	Судалгаанд хамрагдсан ААНБ-ын жилийн борлуулалтын орлого, тоо, хувиар	30
Зураг 3.2.1	Судалгаанд хамрагдсан ХХЭ-дийн насны бүлэг тоо, хувиар	35
Зураг 3.2.2	Судалгаанд хамрагдсан ХХЭ-дийн боловсрол, тоо, хувиар	35
Зураг 3.2.3	ХХЭ-дийн үйл ажиллагаа явуулсан хугацаа, тоо, хувиар	35
Зураг 3.2.4	ХХЭ-дийн ажиллагчдын тооны бүлэг, тоо, хувиар	35
Зураг 3.2.5	ХХЭ-дийн санхүүгийн эх үүсвэр, тоо, хувиар	37
Зураг 3.2.6	Өрхийн үйлдвэрлэлд цалин хөлсгүй ажиллагчдын тоо	37
Зураг 3.3.1	Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тоо, тэргүүлэгчдийн насны бүлгээр	39
Зураг 3.3.2	Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тэргүүлэгчдийн боловсрол	39
Зураг 3.3.3	Судалгаанд хамрагдсан малчин өрх, малын тооны бүлэглэлээр	39
Зураг 3.3.4	Өрхийн үйлдвэрлэлд цалин хөлсгүй ажиллагчийн тоо, насны бүлгээр	40
Зураг 3.3.5	Малчин өрхийн хэрэгцээ	40
Зураг 3.3.6	Малчин өрхийн сургалтын хэрэгцээ	40
Зураг 3.4.1	Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн нас, тоо, хувиар	41
Зураг 3.4.2	Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн боловсрол, тоо, хувиар	41
Зураг 3.5.1	Судалгаанд хамрагдсан ажиллаж буй залуучуудын нас, тоо, хувиар	46
Зураг 3.5.2	Судалгаанд хамрагдсан ажиллаж буй залуучуудын боловсрол, тоо, хувиар	46
Зураг 3.5.3	Ажиллаж буй залуучуудын мэргэжлийн бус ажил хийж байгаа шалтгаан	50
Зураг 3.6.1	Шинэ ажилтан авахад ашигладаг мэдээллийн эх сурвалж, хувиар	53
Зураг 3.6.2	Шинэ ажилтан авахад тулгардаг бэрхшээл, тоо, хувиар	53
Зураг 3.6.3	Ажилтны ажлаас халагдсан шалтгаан, хувиар	54
Зураг 3.6.4	Шинэ ажилтан авахдаа тавьдаг ур чадварын шаардлага, хувиар	54
Зураг 3.6.5	Ажил олгогчдод шаардлагатай дэмжлэг, тоо, хувиар	55
Зураг 3.6.6	Ажил олгогч, сургалтын байгууллагын хамтын ажиллагааны чиглэл, тоо, хувиар	56
Зураг 4.1.1	Их, дээд сургуульд суралцаж буй оюутнуудын “төгсөөд хаана ажиллах вэ?” гэсэн асуултын хариулт	65

ХӨДӨЛМӨРИЙН НЭР ТОМЬЁОНЫ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Аж ахуйн нэгж гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг;

Ажил олгогч гэж ашиг олох зорилгоор тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг цалин хөлстэй ажиллагчаар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг;

Ажил олгогчдыг дотор нь аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч (захирал, менежер) болон өрхийн зах зээлийн аж ахуйн нэгжийн ажил олгогч гэж хоёр ангилна.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол цалин хөлстэй ажиллагчаар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагчийг;

Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол цалин хөлстэй ажиллагчаар ажиллуулж байгаа ажиллагчийг;

Ажил гэж аль ч нас, хүйсийн хүн амын бусдын эсвэл өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх албан ёсны болон албан бус бүхий л үйл ажиллагааг;

Ажил гэсэн ойлголтод бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхээс өөр үйлдэл (гуйлга гуйх, хулгай хийх), өөрийн биеийг арчлах (хувийн ариун цэвэр сахих, арьс арчилгаа хийх, өөрийгөө сувилах) болон тухайн хүний өмнөөс өөр хүн гүйцэтгэж үл чадах үйл ажиллагаа (унтах, суралцах, өөрийгөө хөгжүүлэх, амрах) хамаарахгүй.

Ажлын байр гэж цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан хийж гүйцэтгэх ажил, үүрэг, албан тушаалыг;

Ажлын байр гэж иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор ажил гүйцэтгэх бүх байрыг;

Үндсэн ажлын байр гэж тухайн хүн цалин хөлс, орлого олох зорилгоор хоёр болон түүнээс дээш ажлын байранд хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд тухайн хугацаанд хамгийн их цаг зарцуулсан ажлыг;

Байнгын ажлын байр гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил үүргийг;

Байнгын ажилтан гэж байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

Түр ажлын байр гэж хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, тодорхой нэг ажил үүргийг гүйцэтгэснээр дуусгавар болдог, байнгын давтамжгүй, тохиолдлын шинж чанартай ажил үүрэг, албан тушаалыг;

Түр ажилтан гэж хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарах, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэнийг;

Улирлын ажлын байр гэж улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг ажил, үүрэг, албан тушаалыг;

Улирлын ажилтан гэж улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

Шинэ ажлын байр гэж үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох болон өргөтгөх замаар эдийн засгийн нэгж дэх албан ба албан бус салбарт шинээр бий болсон ажил, үүрэг, албан тушаалыг;
Харин ажиллагчдын шилжилт хөдөлгөөн, тухайлбал ажиллагч тэтгэвэрт гарсны дараа орных нь хүнийг авах, эхийн чөлөөтэй байгаа хүний ажлын байран дээр хүн авч ажиллуулах, орон тоо шилжих, нэгтгэн зохион байгуулах зэрэг тохиолдлыг шинэ ажлын байранд тооцохгүй.

Эдийн засгийн үйл ажиллагаа гэж зах зээлд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг;

Эдийн засгийн бус үйл ажиллагаа гэж Үндэсний тооцооны системийн хүрээнээс гаднах хүүхэд, өндөр настан асрах, гэр цэвэрлэх, хоол унд бэлтгэх зэрэг цалин хөлс, орлого олох зорилгогүйгээр өөрийн хэрэглээний болон бусдын хэрэглээнд зориулж сайн дураар хийж гүйцэтгэсэн үйлчилгээг;

Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг;

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүнийг;

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг;

Ажиллах хүчний эрэлт Ажил олгогчид хэрэгцээтэй хөдөлмөрийн үйлчилгээний хэмжээг;

Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүнийг;

Өргөтгөсөн ажиллах хүч гэж ажиллах хүч, боломжит ажиллах хүчний нийлбэрийг;

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг;

Ажиллагч гэж зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг;

Цалин хөлстэй ажилтангүй бие даасан ажиллагч гэж өөрийн хөрөнгөөрөө бие даан, эсвэл бусадтай хамтран эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж, тухайн хугацаанд ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг;

Ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй гэдэг нь өөрөөсөө, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүнээсээ өөр нэг ч хүн ажилчнаар авч ажиллуулаагүй байхыг ойлгоно. Эдгээр хөдөлмөр эрхлэгчдийг дотор нь цалин хөлстэй ажилтангүй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч болон цалин хөлстэй ажиллагчгүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гэж хоёр ангилна.

Цалин хөлстэй ажилтангүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл хувь эзэмшигч, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж, байгууллагын (хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо) үйл ажиллагааг эрхэлж буй ажиллагчийг;

Цалин хөлстэй ажилтангүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрхэлж явуулдаг ажиллагчийг;

Ажиллагчдад дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

- Ур чадвараа нэмэгдүүлэх зорилгоор салбар болон системийн хүрээнд өөр ажил хийж байгаа эсвэл сургалтад хамрагдаж байгаа хүн;
- Цалинтай ажиллаж байгаа дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дагуу цалин хөлс, орлого олох зорилгоор ажиллаж байгаа хүн;
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийх нь зарим хэсгийг өрх, гэр бүл нь хэрэглэдэг ч голчлон худалдах буюу солилцох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг өөрийн эдийн засгийн нэгждээ ажилладаг хүн;
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ ихэвчлэн өөрийн хэрэглээнд /өрх, гэр бүл/ зориулан үйлдвэрлэдэг хэдий ч зарим тохиолдолд бага хэмжээгээр зах зээлд борлуулснаас олсон орлого нь тухайн хүн, өрхийн орлогын ихэнх хувийг бүрдүүлдэг өөрийн эдийн засгийн нэгждээ ажилладаг хүн;
- Улирлын чанартай ажлынхаа сул зогсолтын үеэр цалин хөлс, орлого олох эсэхээс үл хамааран хуулийн болон захиргааны эрх үүрэг (татвар төлөх), даалгаврыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа хүн;
- Өөрийн өрхийн гишүүн болон өөр өрхөд амьдардаг гэр бүлийн холбоотой хүний зах зээлийн нэгжид ажилладаг хүн эсвэл тэдний цалинтай ажилд туслан, ажил үүргийг гүйцэтгэдэг хүн;
- Зэвсэгт хүчний байгууллагад тогтмол ажилладаг хүмүүс, мөнгөн болон мөнгөн бусаар цалин хөлс авдаг цэргийн болон иргэний үйлчилгээний байгууллагад ажиллаж буй хүн.

Ажиллагчдад дараах хүмүүс хамааруулахгүй. Үүнд:

- Мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаггүй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид;
- Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцолгүйгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ур чадварын сургалт, давтан сургалтад хамрагдаж байгаа хүн;
- Ажилгүйдлийн даатгал, тэтгэвэр гэх мэт төр, засгийн нийгмийн хамгааллын тэтгэмжийг үргэлжлүүлэн авах нөхцөлөөр цалин хөлсгүйгээр ажиллаж байгаа хүн;
- Тухайн эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд оролцдоггүй бөгөөд үйл ажиллагааны ашиг, орлогоос мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр орлого авдаг хүн;
- Тухайн хугацаанд хөдөлмөр эрхлэхгүй байгаа, тогтмол ажлын байргүй улирлын чанартай хөдөлмөр эрхэлдэг хүн;
- Өөрийн ажиллаж байсан эдийн засгийн нэгждээ эргэж ажилд орох эрхтэй боловч ажлаас завсардах босго хугацааг давуулсан бөгөөд цалин хөлсөө авах шалгуурт тэнцээгүй ажлаасаа завсардсан хүн;
- Ажиллаж байсан эдийн засгийн нэгждээ эргэж ажиллах эсэх нь баталгаагүй ажлаас чөлөөлөгдсөн хүн.

Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүнийг;

Хөдөлмөр эрхлээгүй гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг;

Ажил хийхэд бэлэн гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг, мөн ажил хийж эхлэхэд бэлэн байгааг;

Ажил хайж байгаа гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүнийг;

Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно.

Ажил хайгч гэж ажилгүй хүн эсвэл ажиллагч боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн хүнийг;

Бүртгэлтэй ажилгүй хүн гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлээгүй, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлэхэд бэлэн болон Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн ажилгүй хүнийг;

Ажил хийгээгүй болон суралцаагүй байгаа залуучууд гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй, албан боловсрол эзэмших сургуульд суралцаагүй, бүх шатны сургалтад хамрагдаагүй байгаа 15-24 насны ажилгүй болон ажиллах хүчнээс гадуурх залуучуудыг;

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

Ажиллах хүчний оролцооны түвшин=(Ажиллах хүч/Хөдөлмөрийн насны хүн ам)х100%

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин=(Ажиллагчдын тоо/Хөдөлмөрийн насны хүн ам)х100%

Ажилгүйдлийн түвшин: Ажилгүй хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-1).

ХДАТ1=(Ажилгүй хүний тоо/Ажиллах хүч)х100%

БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Үндэслэл, шаардлага:

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15.4-т зааснаар Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага мэргэжлийн сургалтад суралцагч элсүүлэхдээ хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэх үүрэгтэй. Элсэлтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж буй өнөөгийн нөхцөлд тухайн орон нутагт хийгдсэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа зайлшгүй шаардлагатай.

Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийснээр хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн талаарх бодитой мэдээлэл гаргаж Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлтийг төлөвлөхөөс гадна олон нийтэд хүргэх, их, дээд сургуулийн элсэлт, хөдөлмөр эрхлэлт, ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагыг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах боломж бүрдэх юм.

Судалгааны зорилго:

Дорноговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацаа /2021-2023 он/-ны ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг салбар, ажил мэргэжлээр тодорхойлж, боловсролын ба хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг мэдээллээр хангахад оршино.

Судалгааны зорилтууд:

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хэрхэн хангасныг судлан дүгнэх, өнгөрсөн хугацаанд үүссэн ажиллах хүчний хомсдолыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлээр тодорхойлох;
- Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал, үр дүнг судалж, дүгнэх;
- 2021-2023 оны ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, мэргэжлээр тодорхойлох;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүүгийн харьцуулсан шинжилгээ хийх;
- Судалгааны үр дүнг нэгтгэн тайлан бичиж нийтийн хүртээл болгох.

1.2 СУДАЛГААНЫ ТҮҮВЭР, ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгаанд аж ахуйн нэгж, байгууллагууд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчин өрх, ажилгүй иргэд, ажилдаж буй залуучууд, их, дээд сургуульд суралцагчдыг хамруулсан.

Судалгаанд хамруулах ААНБ-ын түүвэр хийхдээ Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 1296 ААНБ-ын 30-аас доошгүй хувийг хамруулахаар түүвэр хийсэн.

Энэхүү судалгаанд Дорноговь аймгийн 14 сумын 406 ААНБ-ыг хамруулав. ААНБ-ийн 214 буюу 52.7 хувийг Сайншанд, Замын-Үүд сумаас, 192 буюу 46.3 хувийг бусад сумаас хамруулсан болно.

2020 оны 3-р улирлын байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй 1875 ААНБ, үүнээс 1296 нь үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд судалгаанд бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ын 21.6 хувь, үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын 31.3 хувь нь хамрагдсан байна.

ААНБ-ыг түүврийн аргаар сонгосон тул энэхүү тайланд үзүүлсэн эрэлт нь тухайн салбар, тухайн үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-ын дүнг үндэслэн тархаасан эрэлт юм.

Дорноговь аймагт 2019 оны жилийн эцсийн тооллогоор 4231 малчин өрх байсан ба энэхүү судалгаанд түүврийн аргаар 14 сумын 471 малчин өрхийг сонгож хамрууллаа. Судалгаанд хамруулах өрхийг сонгохдоо малын тооны бүлэглэл бүрийн 15-30 хувийг хамруулах, тэгэхдээ 201-ээс дээш малтай өрхийг түлхүү хамруулах зарчим баримталсан.

Судалгаанд 201-500 малтай өрх 131, 501-999 малтай өрх 128, 1000-аас дээш малтай өрх 71 хамрагдсан ба тэд судалгаанд хамрагдсан өрхийн 70.1 хувийг эзэлж байна. Дорноговь аймгийн 4231 малчин өрхийн 11.1 хувь хамрагджээ.

Малын тооны бүлэглэлээр авч үзвэл 1000-аас дээш малтай өрхийн 16.1 хувь, 501-1000 малтай өрхийн 27.2 хувь, 201-500 малтай өрхийн 27.8 хувь, 101-200 малтай өрхийн 21.4 хувь хамрагдсан нь бидний баримталсан зарчимтай нийцэж байгаа бөгөөд судалгаанаас гарсан эрэлтийг тархаахад гарах алдааг багасгах боломж олгож байна.

Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж буй 329 хувиараа хөдөлмөр эрхлэгч (ХХЭ)-ийг судалгаанд хамруулсан. Эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл 194 буюу 58.9 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 45 буюу 13.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар, үйлчилгээ, 20 буюу 6.1 хувь нь зочид буудал, байр, сууц, нийтийн хоолны үйлчилгээ, 19 буюу 5.8 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт ажиллаж байгаа ба 62.6 хувь нь 5-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай хувиараа хөдөлмөр эрхлэгчид байлаа.

ХХЭ-дийн 82 буюу 24.9 хувь нь ажилтан авч ажиллуулдаг бөгөөд тэдний 49 буюу 59.8 хувь нь 1 ажиллагчтай, 29 буюу 35.4 хувь нь 2-3 ажиллагчтай ажил олгогч байв.

Судалгаанд Дорноговь аймгийн 724 ажилгүй иргэн хамрагдсан. Тэдний 105 нь бакалавр ба түүнээс дээш боловсролтой, 311 нь мэргэжилтэй ажилгүйчүүд байлаа. Ажилгүй иргэдийн төгссөн мэргэжил, цаашид суралцахыг хүссэн 62 мэргэжлийн жагсаалтыг хүний тоогоор гаргаж эрэлт, нийлүүлэлтийн тэнцэлийг тооцов.

Дорноговь аймаг ажиллаж буй 446 залуучуудаас судалгаа авсан ба тэдний дотор магистр 22, бакалавр 294, дипломын дээд боловсролтой 1, техникийн буюу тусгай дунд боловсролтой 25, мэргэжлийн боловсролтой 24 байсан. 316 буюу 70.8 хувь нь дээд боловсролтой.

133 залуу буюу 29.8 хувь мэргэжлийн бус ажил эрхэлж байгаа нь ямар мэргэжлээр илүүдэл бий болсон, ямар мэргэжилтэй залуучууд ажилгүйдэлд өртөж болзошгүйг тандах боломжийг олгож байна.

Дорноговь аймгаас Улаанбаатар хот, бусад аймгийн их, дээд сургуульд суралцаж буй 575 оюутнаас ямар мэргэжлээр суралцаж байгаа, хэзээ төгсөх, төгсөөд аймагтаа ирж ажиллах эсэх зэрэг асуудлуудаар судалгаа авч, нийлүүлэлтийг тооцож гаргав. Тэдний 487 нь 2021-2023 онд төгсөнө.

Мөн тус аймагт сургалтын үйл ажиллагаа явуулж буй Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль, Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөс судалгаа авч 2021-2023 оны нийлүүлэлтийг тооцсон болно.

1.3 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ

Судалгааны багийг Дорноговь аймгийн Засаг даргын 2020 оны А/46 дугаар захирамжаар 57 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсан. /судалгааны багийн бүрэлдэхүүнийг хавсралтаас үзнэ үү/

Судалгааг зохион байгуулахын тулд 2020 оны 06 дугаар сарын 15-20-ны өдрүүдэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн Үндэсний зөвлөх Д.Нармандах, зөвлөх багш Ч.Наранбилэг нартай хамтарч Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, Мэргэжлийн боловсрол, сургалтын салбар зөвлөлийн гишүүд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, мэргэжлийн сургалтын удирдах ажилтнуудад **“Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа: Оролцогч талуудын үүрэг, хамтын ажиллагаа”**, судалгааны багийн гишүүдэд **“Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа”** сэдэвт сургалт зохион байгуулав.

Судалгааны мэдээлэл цуглуулахад дараах зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- Шинжлэх ухааны үндэслэлтэй, нэгдсэн арга зүйг ашиглах;
- Судалгаанд оролцогчдын мэдээллийн нууцлалыг хамгаалах;
- Асуулга, ойлголт, тодорхойлолтууд нь судлаач, оролцогч, мэдээлэл боловсруулагчдад ойлгомжтой, тодорхой байх;
- Цуглуулсан мэдээлэл нь зорилгод нийцсэн, үнэн бодитой байх;
- Судалгааны үр дүн, тайлан нь тодорхой, ойлгомжтой, хэрэглэгдэхүйц байх

Судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг 2020 оны 9-11 дүгээр сард зохион байгуулж, 11-12 дугаар сард мэдээлэл боловсруулах, шаардлагатай мэдээллүүдийг холбогдох албан тушаалтнуудаар гаргуулж, тайлан бэлтгэх ажлуудыг хийж гүйцэтгэв.

Хөдөлмөрийн зах зээлийн тоон болон чанарын эрэлтийг дараах асуулгын хуудсуудаар авч гаргав.

Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагаас авах санал асуулга
2. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс авах санал асуулга
3. Малчин өрхөөс авах санал асуулга
4. Ажилгүй иргэдээс авах санал асуулга
5. Ажиллаж эрхэлж буй залуучуудаас авах санал асуулга /асуулгуудыг хавсралтаас үзнэ үү/

Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн байдлыг

1. Их, дээд сургуульд суралцагчдаас авах асуулгын хуудас

2. АШУҮИС-ын Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль, Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөс төгсөгчдийн судалгааг хүснэгтээр гаргуулж, нэгтгэн боловсруулалт хийв.

БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1 ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮН АМ


Дорноговь аймгийн хүн ам орон сууцны 2020 оны тооллогын дүнгээс харахад суурин хүн ам 69859, тэдний 34813 буюу 49.8 хувь эмэгтэйчүүд байна. Хүн амыг насны бүлгээр харуулбал:

Хүснэгт 2.1.1. Хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр


	Бүгд	Насны бүлэг												
		0-14	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
Суурин хүн ам	69859	22365	5027	4969	5763	6457	5492	4799	4106	3402	2902	2021	1129	1427
Үүнээс: эмэгтэй	34813	10831	2527	2485	2794	3117	2569	2373	2061	1806	1542	1128	645	935
Хотод	44714	15031	3090	3000	3677	4394	3595	2967	2499	2066	1776	1186	659	774
Хөдөөд	25145	7334	1937	1969	2086	2063	1897	1832	1607	1336	1126	835	470	653

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого. Дорноговь аймгийн нэгдсэн дүн

Зураг 2.1.1. Хүн амын нас, хүйсийн суварга



Зураг 2.1.2. Хүн амын тоо, насны бүтцээр



Хүн амын 61.4 хувь нь хөдөлмөрийн нас (15-59)-ны, 64 хувь нь хот (Сайншанд, Замын-Үүд)-д амьдарч байгаа нь үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх боломж юм. Зураг 2.1.1-д үзүүлсэн аймгийн хүн амын нас, хүйсийн суваргаас харахад 25-39 насныхан олон байгаа нь хүн амын эдгээр бүлгийнхний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд холбогдох байгууллага, нийгмийн түншүүд илүү анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

2.2 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 2.2.1. Аймгийн ажиллах хүчний оролцооны ба хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувиар

Үзүүлэлт	2018 оны III улирал		2019 оны III улирал		2020 оны III улирал		Өсөлт бууралт /хувиар/			
	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	2020/2019		2020/2018	
							Бүгд	Эм	Бүгд	Эм
Ажиллах хүчний оролцооны түвшин	61.0	51.9	66.8	68.6	70.5	66.5	+5.5	-3.06	+15.5	+28.1
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	59.4	51.1	66.6	68.2	67.7	64.0	+1.6	-6.1	+13.9	+25.2

Эх сурвалж: www.1212.mn

Ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 5.5 хувиар, 2018 оноос 15.5 хувиар өссөн бол эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 3.06 хувиар буурч, 2018 оныхоос 28.1 хувиар өсчээ. 2020 оны III улиралд аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин улсын дунджаар 59 хувь байсантай харьцуулбал 11.5 хувиар өндөр байжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оноос 1.6 хувиар, 2018 оноос 13.9 хувиар өссөн бол эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оноос 6.1 хувиар буурсан ч 2018 оноос 25.2

хувиар өсчээ. 2020 оны III улиралд аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин улсын дунджаар 54.7 хувь байсантай харьцуулбал 13.0 хувиар өндөр байжээ.

Хүснэгт 2.2.2. Ажиллах хүч ба ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, хүйс, хот, хөдөөгөөр

	15 ба түүнээс дээш насны хүн ам	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
		Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	47494	30212	29158	1054	17282	6306	4605	1011	1428	2265	91	1576
Үүнээс: эмэгтэй	23982	13778	13258	520	10204	3531	3210	406	1360	1016	23	658
Хотод	29683	17929	17257	672	11754	4217	2954	627	1157	1627	46	1126
Хөдөөд	17811	12283	11901	382	5528	2089	1651	384	271	638	45	450

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого. Дорноговь аймгийн нэгдсэн дүн

15 ба түүнээс дээш насны хүн амын 63.6 хувь, хөдөлмөрийн насны хүн амын 70,4 хувь нь ажиллах хүч байна. Ажиллах хүчний 59.3 хувь нь хотод буюу Сайншанд болон Замын-Үүд суманд байна.

Ажиллах хүчний 96.5 хувь нь ажил эрхэлдэг. Ажил эрхэлж байгаа хүмүүсийн 45.5 хувь нь эмэгтэйчүүд байгаа ба 59.2 хувь нь хотод ажиллаж байна.

Хөдөлмөрийн насны хүн амын 29.5 хувийг ажиллах хүчнээс гадуурх хүн ам эзэлж байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 59.0 хувь нь эмэгтэйчүүд, 68.0 хувь нь хотод буюу Сайншанд болон Замын-Үүд суманд байна.

Хүснэгт 2.2.3. Ажиллах хүч ба ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, сумаар

	15 ба түүнээс дээш насны хүн ам	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
		Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	47494	30212	29158	1054	17282	6306	4605	1011	1428	2265	91	1576
Айраг	2519	1512	1408	104	1007	336	244	84	91	121	1	130
Алтанширээ	972	743	703	40	229	98	69	16	14	26		6
Даланжаргалан	2094	1463	1448	15	631	231	159	38	47	118	22	16
Дэлгэрэх	1289	871	853	18	418	152	178	59	1	21	2	5
Иххэт	1475	891	863	28	584	179	163	45	38	80	1	78
Мандах	1116	815	792	23	301	105	139	18	5	20	2	12
Өргөн	1528	1073	1012	61	455	182	138	28	17	56	2	32
Сайхандулаан	944	721	710	11	223	105	41	13	6	34	10	14
Улаанбадрах	1072	816	810	6	256	99	86	13	3	26		29
Хатанбулаг	2041	1442	1433	9	599	254	182	34	18	46	2	63
Хөвсгөл	1137	822	780	42	315	126	108	20	9	23	1	28
Эрдэнэ	1624	1114	1089	25	510	222	144	16	22	67	2	37
Сайншанд	17281	10072	96646	426	7209	2309	2228	470	495	1014	24	669
Замын-Үүд	12402	7857	7611	246	4545	1908	726	157	662	613	22	457

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого. Дорноговь аймгийн нэгдсэн дүн

Хүснэгт 2.2.4. Ажиллах хүч ба ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, эмэгтэй, сумаар

	15 ба түүнээс дээш насны хүн ам	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
		Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	23512	13778	13258	520	10204	3531	3210	406	1360	1016	23	658
Айраг	1267	663	616	47	604	201	190	29	90	51	1	42
Алтанширээ	465	332	316	16	133	58	50	6	11	6		2
Даланжаргалан	962	586	579	7	376	142	117	16	46	43	4	8
Дэлгэрэх	625	371	364	7	254	94	132	20		7		1
Иххэт	720	376	358	18	344	105	122	25	35	36		21
Мандах	527	345	335	10	182	63	97	5	4	6	2	5
Өргөн	731	460	422	38	271	113	101	8	16	20		13
Сайхандулаан	428	316	313	3	112	60	30	4	6	8	1	3
Улаанбадрах	518	372	369	3	146	61	63	4	3	6		9
Хатанбулаг	912	646	641	5	336	140	124	16	17	15	1	23
Хөвсгөл	515	325	314	11	190	71	82	9	9	12	1	6
Эрдэнэ	779	479	468	11	300	128	111	2	20	26	1	12
Сайншанд	9290	5048	4837	211	4242	1297	1492	196	477	482	7	291
Замын-Үүд	6173	3459	3326	133	2714	998	499	66	626	298	5	222

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого. Дорноговь аймгийн нэгдсэн дүн

Хүснэгт 2.2.5. Ажил эрхлэгчдийн тоо, ажил мэргэжлийн ангиллаар

Ажил мэргэжлийн ангилал	Бүгд		Хот		Хөдөө	
	Бүгд	Үүнээс: эмэгтэй	Бүгд	Үүнээс: эмэгтэй	Бүгд	Үүнээс: эмэгтэй
Бүгд	29158	13258	17257	8163	11901	5095
Менежер	1600	877	1122	636	478	241
Мэргэжилтэн	4137	2843	3063	2140	1074	703
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	1305	731	951	543	354	188
Контор, үйлчилгээний ажилтан	1115	836	784	593	331	243
Худалдаа, үйлчилгээний ажилтан	3209	2331	2397	1750	812	581
Хөдөө аж ахуй, ой, загас, агнуурын мэргэшсэн ажилтан	7155	2937	736	349	6419	2588
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний	1401	308	1119	254	282	54
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	6170	1122	5189	979	981	143
Энгийн ажил мэргэжил	2277	1144	1551	852	726	292
Бусад салбарын ажил мэргэжил	789	129	345	67	444	62

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого. Дорноговь аймгийн нэгдсэн дүн

Ажил эрхлэгчдийн олонхийг хөдөө аж ахуй, ой, загас, агнуурын мэргэшсэн ажилтан 24.5 хувиар, машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч 21,1 хувиар, мэргэжилтэн 14.2 хувиар эзэлж байна.

Хүснэгт 2.2.6. Ажил эрхлэгчдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Бүгд		Хот		Хөдөө	
	Бүгд	Үүнээс: эмэгтэй	Бүгд	Үүнээс: эмэгтэй	Бүгд	Үүнээс: эмэгтэй
Бүгд	29158	13258	17257	8163	11901	5095
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	7164	2962	771	360	6393	2602
Уул уурхай, олборлолт	919	180	468	106	451	74
Боловсруулах үйлдвэрлэл	1424	525	882	361	542	164
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	396	120	304	97	92	23
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	183	79	169	77	14	2
Барилга	1360	372	1031	289	329	83
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ	2297	1335	1686	1025	611	310
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	5087	1419	4562	1268	525	151
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	520	422	442	362	78	60
Мэдээлэл холбоо	221	106	171	84	50	22
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	723	530	565	406	158	124
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	20	10	20	10		
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	305	172	207	113	98	59
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	301	111	242	87	59	24
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	3036	1354	1833	907	1203	447
Боловсрол	2394	1922	1632	1325	762	597
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1119	941	841	716	278	225
Урлаг, үзвэр, тоглоом наадам	254	135	168	83	86	52
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	767	384	603	311	164	73
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	654	173	647	171	7	2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	14	6	13	5	1	1

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого. Дорноговь аймгийн нэгдсэн дүн

Ажил эрхлэгчдийн дийлэнхи олонхийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар 24.5 хувиар, тээвэр агуулахын үйл ажиллагааны салбар 17,4 хувиар, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар 14.4 хувиар, боловсролын салбар 8.2 хувиар, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээний салбар 7.9 хувиар эзэлж байна.

Хамгийн олон ажиллагчтай салбар хотод тээвэр агуулахын үйл ажиллагаа (4562 буюу 15.6 хувь), хөдөөд хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (6393 буюу 21.9 хувь) байна.

Хүснэгт 2.2.7. Ажил эрхлэгчдийн тоо, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар

	Бүгд	Хөдөлмөр эрхлэлтийн байдал									
		Цалин хөлстэй байнгын ажиллагч	Цалин хөлстэй түр ажиллагч	Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	Цалин хөлстэй дагалдан, мэргэшиж буй дадлагажигч, дагалдан дадлагажигчид	Гүйцэт гэх гэрээлэгч	ААНБ-ын ажил олгогч	Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн ажил олгогч	Цалин хөлстэй ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	Цалин хөлстэй ажилтангүй зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн үйл ажиллагаа	Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн
Бүгд	29158	16559	1275	84	5	68	63	70	52	9142	1840
Үүнээс: эмэгтэй	13258	8255	484	35	2	9	28	15	27	3017	1386
Хотод	17257	11841	892	52	2	49	52	14	34	4110	207
Хөдөөд	11901	4718	383	28	3	19	11	56	18	5032	1633

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого. Дорноговь аймгийн нэгдсэн дүн

2.3 ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн зах зээлд ямар эрэлт байсныг ХХҮГ-т ирсэн ажлын байрны захиалгаас харвал:

Хүснэгт 2.3.1. Ажлын байрны захиалгын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	2019 оны I-IX сар	2020 оны I-IX сар
Бүгд	397	1338
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	24	18
Уул уурхай, олборлолт	130	4
Боловсруулах үйлдвэрлэл	1	1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	4	17
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	12	41
Барилга	43	235
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ	4	55
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	2	9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	6	7
Мэдээлэл холбоо		20
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	6	2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		378
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	36	49
Боловсрол	40	36
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	7	48
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	17
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	87	400
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн ү/а, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		

Эх сурвалж: Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулга. 2020/09

Хүснэгт 2.3.2. Ажлын байрны захиалгын тоо, ажил мэргэжлийн ангиллаар


Ажил мэргэжлийн ангилал	2019 оны I-IX сар	2020 оны I-IX сар
Бүгд	397	1338
Менежер	8	27
Мэргэжилтэн	55	524
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	58	63
Контор, үйлчилгээний ажилтан	25	198
Худалдаа, үйлчилгээний ажилтан	22	91
Хөдөө аж ахуй, ой, загас, агнуурын мэргэшсэн ажилтан	15	1
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний	30	132
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	42	35
Энгийн ажил мэргэжил	135	191
Бусад салбарын ажил мэргэжил	7	76

Эх сурвалж: Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулга. 2020/09

Дээрх 2 хүснэгтээс харахад 2020 онд ажил олгогчдоос 1338 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оноос 941-ээр нэмэгджээ. Захиалгын дийлэнх олонхи нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 400 (29.9%), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 378 (28.2%), барилгын салбарт 235 (17.6%) байсан.

Ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл мэргэжилтэн 524 (39.2%), контор, үйлчилгээний ажилтан 198 (14.8%), энгийн ажил мэргэжил 191 (14.3%), үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил мэргэжил 132 (9.8%) иржээ.

Зураг 2.3.1. Ажлын байрны захиалгын тоо, өмчийн хэлбэрээр



Эх сурвалж: Дорноговь аймгийн ХХҮГ-ын статистик мэдээ. 2020/09

Зураг 2.3.2. Ажлын байрны захиалгын тоо, хариуцлагын хэлбэрээр




Эх сурвалж: Дорноговь аймгийн ХХҮГ-ын статистик мэдээ. 2020/09

Ажлын байрны захиалгыг өмчийн хэлбэрээр авч үзвэл төрийн өмчийн байгууллага 670 (50.1%), Монгол улсын хувийн ААН 582 (43.5%), хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төсөвт байгууллага 660 (49.3%), хязгаарлагдмал хариуцлагатай компани 277 (20.7%), төрийн бус байгууллага 231 (17.3%) захиалга ирүүлжээ.

Хүн ам, орон сууцны тооллогын үеэр 1054 ажил хайгч иргэн, тэдний 520 буюу 49.3 хувь нь эмэгтэйчүүд байв. Ажил хайгч иргэний боловсролыг авч үзвэл:

Зураг 2.3.3. Ажил хайгч иргэний тоо, боловсролын түвшин, хувиар



Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого. Дорноговь аймгийн нэгдсэн дүн

Зураг 2.3.3-аас харахад ажил хайгч иргэдийн 70 хувь нь мэргэжилгүй, 16 хувь нь магистр, бакалаврын зэрэгтэй байна.

Ажилгүй болон ажил хайгч иргэний тоо сар, улирал бүр өөрчлөгдөж байдаг. Хүн ам, орон сууцны тооллогын үеэр 1054 ажил хайгч иргэн байсан бол 2020 оны 3-р улиралд 320 болж хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс 734-өөр буюу 69.6 хувиар, 2019 оны мөн үеэс 31.9 хувиар тус тус буурчээ.

Хүснэгт 2.3.3. Ажил хайгч иргэний тоо, боловсролын түвшингээр

Үзүүлэлт	2018 оны III улирал	2019 оны III улирал	2020 оны III улирал	Өсөлт бууралт /хувиар/ 2020/2019	2020/2018
Бүгд	965	470	320	68.1	33.2
Үүнээс: эмэгтэй	468	226	171	75.7	36.5
Магистр, доктор	2	1	1	100.0	50.0
Бакалавр	161	56	103	183.9	64.0
Тусгай дунд буюу техникийн	33	10	15	150.0	45.4
Мэргэжлийн	64	12	20	166.7	31.2
Бүрэн дунд	624	349	165	47.3	26.4
Суурь	49	28	7	25.0	14.3
Бага	8	2	5	250.0	62.5
Боловсролгүй	24	12	4	33.3	16.7

Эх сурвалж: Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулга. 2020/09

2020 оны III улиралд ажил хайгч иргэдийн 103 буюу 32.2 хувь нь бакалаврын зэрэгтэй иргэн байсан ба 2019 оноос 83.9 хувиар өссөн байна.

2020 оны III улирлын байдлаар ажил хайгч иргэдийн 181 буюу 57.8 хувь нь мэргэжилгүй иргэд байна. Мэргэжилгүй ажил хайгчдын тоо 2018 оны мөн үеэс 524-өөр, 2019 оны мөн үеэс 210-аар тус тус буурчээ.

Хүснэгт 2.3.4. Ажил хайгч иргэний тоо, сумаар

	Ажил хайгч иргэний тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
Ажил олгогчийг төлөөлүүлж 406 ААНБ, 329 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 471 малчин өрх, улс, орон нутаг болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд ажлын бий болгох 6 аж ахуйн нэгжийн 15 бүтээн байгуулалтын ажлын талаарх мэдээлэлд боловсруулалт хийж Дорноговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлов.

Судалгааны дүнгээс харахад дунд хугацаа (2021-2023 он)-ны эрэлт **4691** байгаагаас ААНБ-уудад 121 мэргэжлээр 750, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 13 мэргэжлээр 90, малчин өрхөд 1 мэргэжлээр 123, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 108 мэргэжлээр 3728 эрэлт байна.

Их, дээд сургуульд суралцаж буй оюутнууд, Дорноговь аймагт Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль, Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгч, ажилгүй иргэд, ажил эрхэлж буй залуучуудын судалгааг авч нэгтгэн боловсруулалт хийж дунд хугацааны нийлүүлэлтийн төлөв байдлыг тооцсон.

Судалгаагаар Дорноговь аймгаас их, дээд сургуульд суралцаж байгаа 487 оюутан 2021-2023 онд 143 мэргэжлээр төгсөнө. Ойрын 3 жилд Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургууль 20 мэргэжлээр 423 эмч, эрүүл мэндийн ажилтан, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 15 мэргэжлээр 746, Төмөр замын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 7 мэргэжлээр 1140 мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ.

Боловсрол, мэргэжил эзэмшсэн 313 (90 мэргэжлээр төгссөн) иргэн ажилгүй байгаа бол ажил эрхэлж байгаа залуучуудын дотор 67 мэргэжлээр төгссөн 116 залуу мэргэжлийн бус ажил эрхэлж байна. Энэ бүгдийг тооцож үзвэл их, дээд сургууль, МСҮТ-өөс 2775, ажилгүй иргэн болон мэргэжлийн бус ажил эрхэлж буй залуучууд нийлээд 429, бүгд **3204** мэргэжилтэн, мэргэжилтэй ажилтны нийлүүлэлт хийгдэж болохоор байна.

Хамгийн их эрэлт, нийлүүлэлттэй мэргэжлүүдийн эрэлт ба нийлүүлэлтийн байдлыг доорхи хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 5.1.2. Хамгийн их эрэлттэй мэргэжлүүдийн эрэлт, нийлүүлэлтийн харьцаа

№	Мэргэжил	Эрэлт /оноор/				Нийлүүлэлт	Ажиллах хүчний	
		2021	2022	2023	Нийт		илүүдэл	хомсдол
1	Төмөр замын замчин		650		650	179		471
2	Барилгын засал чимэглэл	112	101	100	313	82		231
3	Гагнуурчин	30	130	132	292	97		195
4	Хүнд даацын машины жолооч	73	90	90	253	25		228
5	Механикч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	59	84	88	231			231
6	Барилгын өрөг угсрагч	52	70	70	192	4		188
7	Туслах ажилтан, үйлдвэрлэлийн	31	71	75	177			177
8	Техникч, цахилгааны	50	50	50	150	1		149
9	Барилга угсралтын мужаан	25	60	50	135			135
10	Туслах малчин	71	29	23	123			123
11	Металл хийцийн угсрагч	10	55	55	120			120
12	Жолооч, машины	43	51	20	114	24		90
13	Бетон арматурчин	10	50	50	110			110
14	Засалчин шаварчин	50	50		100			100
15	Тогооч	36	33	30	99	110	11	
16	Вагон үзэгч, засварчин		97		97	120	23	
17	Илчит тэрэгний засварчин		87		87	124	37	
18	Зүтгүүрийн туслах машинч		80		80	261	181	
19	Операторч, өргүүрийн	10	30	30	70			70
20	Туслах ажилтан, барилгын	24	20	22	66			66

21	Сантехникч	17	26	23	66	7		59
22	Инженер, иргэний барилгын	22	21	20	63	16		47
23	Угсрагч, машин механизмын	20	20	20	60			60
24	Угсрагч, дамжуулах хоолойн		30	30	60			60
25	Шалчин, өнгөлгөөчин	20	20	20	60			60
26	Автомашинны механикч	10	20	30	60			60
27	Техникч, уурхайн	14	20	20	54			54
28	Техникч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн	3	18	30	51			51
29	Техникч, химийн	10	20	20	50			50

Хүснэгт 5.1.3. Хамгийн их нийлүүлэлттэй мэргэжлүүдийн нийлүүлэлт, эрэлтийн харьцаа

№	Мэргэжил	Нийлүүлэлт /оноор/					Эрэлт	Ажиллах хүчний	
		2021	2022	2023	Бусад	Нийт		илүүдэл	хомсдол
1	Зүтгүүрийн туслах машинч	117	72	60	12	261	80	181	
2	Сувилагч /дипломын зэрэгтэй/	29	28	130	0	187		187	
3	Төмөр замын замчин	92	41	40	6	179	650		471
4	Хүний их эмч, ерөнхий мэргэжлийн	40	45	43	3	131	31	100	
5	Төмөр замын өртөөний жижүүр	66	30	30	2	128	46	82	
6	Илчит тэрэгний засварчин	59	35	30	0	124	87	37	
7	Вагон үзэгч, засварчин	61	25	30	4	120	97	23	
8	Тогооч	27	21	23	39	110	99	11	
9	Ачаа, вагон хүлээлцэгч	35	36	30		101	46	55	
10	Гагнуурчин	22	30	33	12	97	192		95
11	Механикч, автомашины	26	33	35	2	96	10	86	
12	Компьютерийн график дизайн	18	34	34	1	87		87	
13	Барилгын засал чимэглэл	16	19	23	24	82	313		231
14	Цахилгаанчин, барилгын	21	24	28	0	73	2	71	
15	Эрх зүйч /хуульч/	20	20	5	18	63	8	55	
16	Техникч, лабораторийн	21	20	16	0	57	2	55	
17	Гар урлалын ажилтан	12	10	19	2	43		43	
18	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	23	11	2	4	40	13	27	
19	Эм найруулагч	9	9	20	0	38		38	
20	Нягтлан бодогч	7	3	4	17	31	43		12
21	Эдийн засагч	10	6	1	12	29	2	27	
22	Хүнд даацын машины жолооч	18	0	0	7	25	253		228
23	Жолооч, машины	0	0	0	24	24	114		90
24	Багш, бага ангийн	15	4	2	2	23	16	7	
25	Оёдолчин, оёмол бүтээгдэхүүний	21				21	3	18	

Хамгийн их эрэлттэй мэргэжлүүд дотор төмөр замын замчин, барилгын засал чимэглэл, гагнуурчин, хүнд даацын машины жолооч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн механикч, барилгын өрөг угсрагч, үйлдвэрлэлийн туслах ажилтан, цахилгааны техникч, барилга угсралтын мужаан, туслах малчин, металл хийцийн угсрагч, автомашины жолооч, бетон арматурчин, засалчин шаварчин гэсэн мэргэжлүүд 100-аас дээш эрэлттэй байгаа бөгөөд бүгд нийлүүлэлтээсээ давсан тул ажиллах хүчний

хомсдол бий болохоор харагдаж байна.

Ойрын 3 жилд нийт 204 мэргэжлээр 5725 (2021 онд 1386, 2022 онд 2740, 2023 онд 1599) ажлын байр бий болох ба үүний 171 мэргэжилд нь 4573 ажиллах хүч дутагдана.

Эрэлттэй мэргэжил бүрийн талаарх мэдээллийг хүснэгт 5.1.1 (Дорноговь аймгийн 2021-2023 оны эрэлт, нийлүүлэлтийн тэнцэл, үл нийцэл)-ээс үзнэ үү.

Хамгийн их нийлүүлэлттэй мэргэжлүүд дотор зүтгүүрийн туслах машинч, сувилагч /дипломын зэрэгтэй/, төмөр замын замчин, хүний их эмч, төмөр замын өртөөний жижүүр, илчит тэрэгний засварчин, вагон үзэгч засварчин, тогооч, ачаа вагон хүлээлцэгч, гагнуурчин, автомашины механикч, компьютерийн график дизайн, барилгын засал чимэглэл, барилгын цахилгаанчин, эрх зүйч /хуульч/, лабораторийн техникч мэргэжлүүд 50-иас дээш нийлүүлэлттэй байгаа бөгөөд төмөр замын замчин, гагнуурчин, барилгын засал чимэглэл гэсэн 3 мэргэжлээс бусад нь эрэлтээс илүү нийлүүлэлт байна.

Ойрын 3 жилд нийт 209 мэргэжлээр 2775 мэргэжилтэн, мэргэжилтэй ажилтны нийлүүлэлт хийгдэнэ.

Хүснэгт 5.1.1-ээс харахад **334 мэргэжлийн эрэлт, нийлүүлэлт нийцэхгүй байна.** Үүний 164 мэргэжил нь нийлүүлэлтийн илүүдэлтэй, 170 мэргэжлээр ажиллах хүчний хомсдолтой байна.

Дорноговь аймгаас их, дээд сургууль, МСҮТ-д суралцагчдаас 2021-2023 онд 2346 мэргэжилтэн, мэргэжилтэй ажилтан бэлтгэгдэж төгсөх бөгөөд тэдний 117 мэргэжлийн 1308 төгсөгчид ажлын байр байхгүй байна.

Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн талаарх мэдээлэл байхгүйгээс 1308 иргэн орон нутагт эрэлтгүй буюу эрэлтээс илүү нийлүүлэлт хийгдэж буй мэргэжлээр элссэн байна.

Дорноговь аймагт сургалтын үйл ажиллагаа явуулж буй Анагаах ухааны сургууль, МСҮТ, Төмөр замын МСҮТ 2021-2023 онд 22 мэргэжлээр 2343 мэргэжилтэн, мэргэжилтэй ажилтан бэлтгэж төгсгөх ба тэдний 1339 төгсөгч буюу 57.2 хувь нь мэргэжлээрээ ажиллах боломжтой байна.

Ажилгүй иргэд, мэргэжлийн бус ажил эрхэлж буй залуучуудаас тогоочоор 33, эрх зүйчээр 32, төмөр замын замчнаар 23, нягтлан бодогчоор 23, оёдлын техникчээр 13, эдийн засагчаар 12, бизнесийн удирдлагаар 11, цэцэрлэгийн багшийн туслах багшаар 8, сэтгэл зүйчээр 7, цэцэрлэгийн багшаар 6 хүн суралцахыг хүсэж байна.

Гэтэл оёдлын техникч, бизнесийн удирдлага, сэтгэл зүйч, цэцэрлэгийн багш мэргэжлүүдээр эрэлт байхгүй, тогооч, эрх зүйч, эдийн засаг, цэцэрлэгийн багшийн туслах багш мэргэжлүүд ажиллах хүчний илүүдэлтэй байна.

Энэ нь иргэдэд хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээлэл байхгүйг илтгэж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс авсан чанарын судалгааны дүнгээс харахад ажилтнууд **“ажлын хариуцлага, сахилга алдсан”, “ажлын ачаалал даахгүй байсан”, “мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувд тэнцээгүй”** гэсэн шалтгаанаар ажлаас халагдсан байна.

Ажил олгогчид ажилтан авахад **“ажилд хандах хандлага төлөвшөөгүй”, “ажлын туршилага байхгүй”, “мэргэжлийн ур чадвар хангалтгүй”** гэсэн хүндрэл учирч байна гээд

“ажилд хариуцлагатай хандах”, “харилцааны ур чадвартай”, “ажлын ачаалал даах”, “багаар ажиллах чадвартай”, “мэргэжлийн ур чадвартай” иргэнийг ажилд авахаа илэрхийлжээ.

Иймд хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн тоон судалгаанд үндэслэн эрэлттэй мэргэжлээр нийлүүлэлт хийхээс илүүтэй чанарын эрэлт буюу мэдлэг, ур чадвар, хандлагын хувьд тэнцэх иргэнийг нийлүүлэх нь чухал гэдгийг анхаарах нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ

Дорноговь аймагт 2020 онд хийсэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааны үр дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна.

Бодлого боловсруулагчдад:

- Судалгааны үр дүнг аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөнд ашиглах, улс, орон нутаг болон хувийн хэвшлийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болох ажлын байранд орон нутгийн ажиллах хүчийг ажиллуулах замаар ажилгүй иргэд, төгсөгчдийг ажлын байртай болгох, үүний тулд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар сургалтын байгууллагуудтай хамтарч төмөр замын замчин, барилгын засал чимэглэл, хүнд даацын машины жолооч, барилгын өрөг угсрагч, гагнуурчин, барилга угсралтын мужаан, металл хийцийн угсрагч, бетон арматурчин гэх мэт ажиллах хүчний хомсдол бий болох мэргэжлүүдээр богино хугацааны сургалт зохион байгуулан ажилгүй иргэд, залуучууд, төгсөгчдийг сургаж мэргэшүүлэх;

- Жижиг, дунд үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих замаар байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх;

- ХХҮГ хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааны үр дүнг орон нутгийн телевизээр нэвтрүүлэх, хэвлэлд нийтлэх замаар ажил олгогч, иргэдэд хүргэх, ялангуяа, өндөр эрэлттэй мэргэжил, нийлүүлэлтийн илүүдэл бий болж буй мэргэжлийн талаарх мэдээллийг Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтарч олон хэлбэрээр хийх, сумын хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтнээрээ дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг байнга зохион байгуулах;

- Нийлүүлэлтийн илүүдэлтэй байгаа болон цаашид нийлүүлэлтийн илүүдэл бий болох мэргэжлүүдээр элсэлт зохион байгуулахгүй байх, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 2025, 2026 онуудад бий болох ажлын байранд шаардлагатай мэргэжлүүдээр оюутан элсүүлэн суралцуулах асуудлыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Их, дээд сургуулиудын консерциум, их, дээд сургуулиудад тавьж шийдвэрлүүлэх;

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг ажилгүй иргэд, залуучууд, сурагч, эцэг эхчүүдэд олон хэлбэрээр зохион байгуулах замаар мэргэжлээ зөв сонгоход туслах.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад:

- Элсэлтээ хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх;
- Эрэлттэй шинэ мэргэжлээр сургалт явуулах боломжийг судлан шийдвэрлэх;
- Бүтээн байгуулалтын ажлын хүрээнд бий болох ажлын байранд шаардлагатай, ажиллах хүчний хомсдол үүсэх мэргэжлүүдээр богино хугацааны болон 1 жилийн сургалт эрхлэх асуудлыг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэн ХХҮГ-тай хамтарч сургалтыг зохион байгуулах;
- Төгсөгчдийн мөшгөх судалгаанд үндэслэн эрэлт, нийлүүлэлтийн байдалд шинжилгээ хийдэг байх;
- Эрэлттэй мэргэжил бүрээр ажил олгогчидтой хамтарч чанарын судалгаа (ажил мэргэжлийн дүн шинжилгээ эсвэл, Дакумын бүдүүвч боловсруулах) хийх замаар мэдлэг, ур чадвар, хандлагыг нарийн тогтоож сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх;
- Суралцагчдад хөдөлмөрийн эерэг хандлага, зөв төлөвшил олгоход анхаарч ажиллах.

ХАВСРАЛТ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/НБ-2

Сайншанд сум

Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дорноговь аймагт хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнгийн тоон болон чанарын судалгааг зохион байгуулсугай.
2. Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийх комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
3. Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үнэн зөв бодитой гарган 2020 оны 11 дүгээр сард багтаан аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг комисст үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Ганзориг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Т.ЭНХТҮВШИН



44 1 20 1194

Аймгийн Засаг даргын _____-оны
____ дугаар сарын ____ ны өдрийн
А/____-р захирамжийн хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Комиссын дарга: - Аймгийн Засаг даргын Орлогч
- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
 - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
 - Статистикийн хэлтсийн дарга
 - Татварын хэлтсийн дарга
 - Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
 - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
 - Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
 - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
 - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
 - АШУҮИС-ийн Дорноговь салбар дахь сургуулийн захирал
 - Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын дарга
 - Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
 - Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн
 - Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга
- Нарийн бичгийн дарга:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, Жендэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн
 - Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал
 - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга

КОМИССЫН СУДАЛГАА АВАХ ДЭД БҮРЭЛДЭХҮҮН

- Ахлагч: - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга
- Гишүүд: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, Жендэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд хариуцсан ахлах мэргэжилтэн
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Орон нутгийн бодлого шийдвэрийн хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн Сургалтын албаны дарга
- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн судалгааны ажилтан
- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн номын санч
- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн цахим мэдээлэл хариуцсан ажилтан
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлал хариуцсан мэргэжилтэн
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвийн ажлын албаны нарийн бичгийн дарга
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвийн сургалт хариуцсан ажилтан
- Нийгмийн даатгалын хэлтсийн Үйлчилгээний тасгийн дарга
- Нийгмийн даатгалын хэлтсийн сургалт, сурталчилгаа, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар

- тариалан хариуцсан мэргэжилтэн
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар бэлчээр ус хангамж хариуцсан мэргэжилтэн
- Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
- Статистикийн хэлтсийн гэрээт ажилтан
- Татварын хэлтсийн татварын улсын ахлах байцаагч
- Улсын бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн
- Боловсрол, соёл, урлагийн газрын Түүх, нийгмийн ухаан хариуцсан мэргэжилтэн
- Насан туршийн боловсролын төвийн захирал
- Сайншанд сумын ЗДТГ-ын Нийгмийн бодлогын тасгийн дарга
- Сайншанд сумын ЗДТГ-ын Нийгмийн бодлогын тасгийн Боловсрол, соёл, урлаг, биеийн тамир спорт хариуцсан мэргэжилтэн
- Худалдаа аж үйлдвэрийн танхимын менежер
- Ажил олгогч эздийн холбооны менежер
- АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн дотоод хяналт, шинжилгээ хариуцсан албаны дарга дарга
- АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн багш
- АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн сувилахуйн багш

КОМИССЫН СУДАЛГААНЫ БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ ДЭД БҮРЭЛДЭХҮҮН

- Ахлагч: - Мэргэжлийн боловсрол, сургалтын төвийн захирал
- Гишүүд: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, Жендэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн
 - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга
 - Статистикийн хэлтсийн дарга
 - Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн Сургалтын албаны дарга

- АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн багш
- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн судалгаа мэдээлэл, хариуцсан мэргэжилтэн
- Худалдаа аж үйлдвэрийн танхимын менежер

---000---

АЖИЛ ОЛГОГЧООС АВАХ САНАЛ АСУУЛГА

Та судалгаанд хамрагдаж үнэн зөв хариулснаар Дорноговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлоход хувь нэмрээ оруулах болно.

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Танай аж ахуйн нэгж, байгууллага (цаашид “ААНБ” гэх) хэдэн онд байгуулагдсан бэ?

2. ААНБ-ийн нэр, хариуцлагын хэлбэр:

- | | |
|---|--|
| а. Хувьцаат компани | е. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар |
| б. Хязгаарлагдмал хариуцлагатай компани | ж. Төсвийн байгууллага |
| в. Хоршоо | з. Төрийн бус байгууллага |
| г. Нөхөрлөл | и. Бусад |
| д. Төрийн өмчит үйлдвэрийн газар | |

3. Үйл ажиллагааны чиглэл:

4. Оршин байгаа хаяг:

5. Танай ААНБ аль салбарт хамаарах вэ?

1. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур
2. Уул уурхай, олборлолт
3. Боловсруулах үйлдвэрлэл
4. Цахилгаан, хий, уур, агааржуулалт
5. Усан хангамж; сувагжилтын систем,, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа
6. Барилга
7. Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ
8. Тээвэр, агуулахын үйл ажиллагаа
9. Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ
10. Мэдээлэл, холбоо
11. Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа
12. Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа
13. Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа
14. Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа
15. Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал
16. Боловсрол
17. Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа
18. Урлаг, үзвэр, тоглоом наадам
19. Үйлчилгээний бусад үйл ажиллагаа
20. Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, хэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ
21. Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа

6. Ажиллагсдын дансны дундаж тоогоороо танай ААНБ алинд нь хамаарагдах вэ?

- | | |
|----------------------------|--------------------------------|
| 1. 14 хүртэл ажиллагсадтай | 5. 100-299 ажиллагсадтай |
| 2. 15-29 ажиллагсадтай | 6. 300-499 ажиллагсадтай |
| 3. 30-49 ажиллагсадтай | 7. 500-гаас дээш ажиллагсадтай |
| 4. 50-99 ажиллагсадтай | |

7. Жилийн борлуулалтын орлогоороо танай ААНБ аль бүлэгт хамаарагдах вэ?

- | | |
|---------------------------|-----------------------------|
| 1. 50 хүртэл сая төгрөг | 2. 50-250 сая төгрөг хүртэл |
| 3. 1 тэрбум төгрөг хүртэл | 4. 1,5 тэрбум төгрөг хүртэл |
| 5. 1,5 тэрбумаас дээш | |

Б. ЗАХ ЗЭЭЛИЙН БАЙДАЛ

8. Сүүлийн 2-3 жилд танай ААНБ-ийн ажиллагсдын тооны өөрчлөлтийг та хэрхэн тодорхойлох вэ?

- 8.1. Ажиллагсдын тоо ихээхэн нэмэгдсэн (20-иос дээш хувь)
- 8.2. Бага зэрэг нэмэгдсэн (5-20 хүртэл хувь)
- 8.3. Бараг өөрчлөгдөөгүй (5 хүртэл хувиар нэмэгдсэн буюу буурсан)
- 8.4. Бага зэрэг буурсан (5-20 хүртэл хувь)

8.5. Ихээхэн буурсан (20-иос дээш хувь)

8.6. Мэдээлэл байхгүй тул тодорхойлж чадахгүй

9. Танай ААНБ одоо ажилтнуудаа цомхотгож байгаа юу?

1. Цомхотгохгүй байгаа

3. Бөөнөөр нь халж байгаа

2. Цөөн орон тоо цомхотгож байгаа

4. Энэ асуултад хариулахгүй

10. Өнөөдөр танай ААНБ ямар мэргэжлийн хүнийг ажилд авч болохоор байна вэ?

(Шаардлагатай мэргэжил, сул байгаа орон тоогоо бичнэ үү)

№	Мэргэжил	Сул орон тоо
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		

11. Танай ААНБ-ийн ойрын 2-3 жилд ажиллах хүчний хөдөлгөөнд ямар өөрчлөлт орох төлөвтэй байгаа вэ?

11.1. Ажиллагчдын тоо ихээхэн нэмэгдэнэ (20-иос дээш хувь)

11.2. Бага зэрэг нэмэгдэнэ (5-20 хүртэл хувь)

11.3. Бараг өөрчлөгдөхгүй (5 хүртэл хувиар нэмэгдэх буюу буурна)

11.4. Бага зэрэг буурна (5-20 хүртэл хувь)

11.5. Ихээхэн буурна (20-иос дээш хувь)

11.6. Мэдээлэл байхгүй тул хэлэхэд бэрхшээлтэй байна

В. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

12. Танай ААНБ ойрын 3 жилд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна уу?

А.Тийм

Б.Үгүй

13. Танай ААНБ-ийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ хэдэн хувиар нэмэгдэх бол

Он	1-10%	11-20%	21-30%	30%-иас дээш
2021				
2022				
2023				

Г. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

14. Танай ААНБ-д ямар мэргэжлийн ажиллагчид ажилладаг вэ?

№	Мэргэжил	Нийт	Үүний дотор: Эм
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			

15. Танай ААНБ-д мэргэжил шаардах ажилд мэргэжлийн бус хүн ажиллаж байгаа юу?

а. Тийм

б. Үгүй

16. Хэрвээ “тийм” бол мэргэжил шаардах аль ажлын байранд өөр ямар мэргэжилтэй хүн ажиллаж байгаа вэ?

№	Мэргэжил шаардах ямар ажлын байранд	Ямар мэргэжилтэй хүн ажиллаж байгаа	Тоо
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			

17. Танай ААНБ-аас ойрын 3 жилд өндөр насны тэтгэвэрт гарах ажилтны тоо:

№	Мэргэжил	2021 он	2022 он	2023 он
1				
2				
3				
4				
5				

Д. АЖЛЫН БАЙРНЫ ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ (Мэргэжлээр)

18. Танай ААНБ ойрын 3 жилд ямар мэргэжлийн ажилтан ажилд авах хэрэгцээтэй вэ?

№	Шаардагдах мэргэжлийн нэр	Шаардагдах ажиллагсдын тоо		
		2021 он	2022 он	2023 он
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				

19. Шинэ ажилтан яаж элсүүлдэг вэ? (Хамгийн их хэрэглэдэг гурав хүртэл аргаа дугуйлна уу)

- а. Ажилд орох гэсэн хүн өөрсдөө бидэнд ханддаг
- б. Бусдын аман мэдээлэлд үндэслэдэг
- в. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, албанд ханддаг
- г. Хэвлэл, радио, мэдээллийн хэрэгслээр зарладаг
- д. Хөдөлмөрийн хувийн биржид ханддаг
- е. Интернетээс
- ж. Бусад

20. Үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнуудаа хаанаас голчлон бүрдүүлдэг вэ? (Хамгийн гол гурван эх үүсвэрээ дугуйлна уу)

- а. Боловсролгүй, бага, дунд боловсролтой хүмүүсээс
- б. Албан бус боловсрол, сургалтын байгууллагад мэргэжил, мэргэшил эзэмшсэн хүмүүсээс
- в. МСҮТ, политехник коллеж, их, дээд сургууль төгсөгчдөөс
- г. Гадаадад ажиллаж байгаад эх орондоо ирсэн хүмүүсээс
- д. Түр сургалтын байгууллага, курс төгсөгчдөөс
- е. Ажилгүйчүүдээс

21. Ажилтан авахад ямар бэрхшээл тулгардаг вэ?

- | | |
|------------------------------------|--------------------------------------|
| а. Мэргэжлийн хүн олдохгүй | д. Ажилд хандах хандлага төлөвшөөгүй |
| б. Мэргэжлийн ур чадвар хангалтгүй | е. Ажлын туршлага байхгүй |
| в. Мэргэжлийн мэдлэг дутмаг | ж. Хос мэргэжилтэй хүн олдохгүй |
| г. Мэргэшсэн ажилтан олдохгүй | з. Бусад |

22. Танайхаас халагдсан ажилтнуудын дотор аль үндэслэлээр халагдсан ажилтан илүү их байсан бэ? (Хамгийн их давтагдсан гурав хүртэл үндэслэлийг дугуйлна уу)

- | | |
|--|--------------------------------------|
| а. Ажлын байрны орон тоо хасагдсан | е. Хугацаат цэргийн албанд татагдсан |
| б. Ажилтан мэргэжил, ур чадварын хувьд тэнцээгүй | ж. Ажлын ачаалал даахгүй байсан |
| в. Ажлын хариуцлага, сахилга алдсан | з. Цалин голсон |
| г. Эрүүл мэндийн хувьд тэнцээгүй | и. Бусад шалтгаан (бичнэ үү) |
| д. Өндөр насны тэтгэвэрт гарах нас хүрсэн | |

23. Танайх сүүлийн 3 жилд үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнуудаа сургалтад хамруулсан уу?

- а. Тийм б. Үгүй

24. Хэрвээ “тийм” бол ямар сургалтад:

- | | |
|---|-----------------------|
| а. Мэргэжлийн боловсрол, сургалтад | г. Дагалдан сургалтад |
| б. Үйлдвэрлэл дээр мэргэшлийн зэрэг ахиулахад | д. Их, дээд сургуульд |
| в. Үйлдвэрлэл дээр мэргэжил олгоход | е. Бусад (бичнэ үү) |

25. Ажилтан сургахад тулгарч буй бэрхшээл бий юу?

- а. Тийм б. Үгүй

26. Хэрвээ “тийм” бол ямар бэрхшээл тулгарч байна вэ? (Хамгийн хүндрэлтэй гурван бэрхшээлийг дугуйлна уу)

- а. Сургалтын өртөг өндөр
- б. Салбарын өргөн мэргэжлээр ажиллах хүч бэлтгэдэггүй
- в. Сургалтын байгууллагын сургалтын чанар муу
- г. Мэдээлэл дутмаг
- д. Үйлдвэрлэл дээр сургалт явуулах боломж хомс
- е. Үйлдвэр дундын сургалтын байгууллага байхгүй
- ж. Бусад (бичнэ үү)

27. Танайх үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтан авахдаа дараах ур чадвар, хандлагаас алийг нь голчлон шаарддаг вэ?

- | | |
|--------------------------------------|---|
| а. Ажлын ачаалал даах | е. Өмч хөрөнгөд өөриймсөг хандах хандлага |
| б. Багаар ажиллах чадвар | ж. Сахилга, дэг журам сахих чадвар |
| в. Ажилд хариуцлагатай хандах чадвар | и. Компьютерийн мэдлэг, чадвар |
| г. Харилцааны ур чадвар | к. Бусад (бичнэ үү) |
| д. Мэргэжлийн ур чадвар | |

28. Танай ААНБ ямар мэргэжлээр ажилтны мэргэшлийн түвшинг ахиулах сонирхолтой байна вэ? (Нэрлэж бичнэ үү)

1.
2.
3.
4.
5.

29. Таны эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжилд ажилтны дараах ур чадвараас аль нь илүү нөлөөлж байна вэ? (Олон хариулт байж болно)

- а. Үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжилтэй ажилтны онолын мэдлэг
- б. Үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжилтэй ажилтны практик ур чадвар
- в. Шинэ техник, технологийн мэдлэг
- г. Аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар
- д. Харилцааны соёл, ур чадвар
- е. Гадаад хэлний мэдлэг, чадвар
- ж. Компьютерийн мэдлэг, чадвар
- и. Ажил хөдөлмөрт хандах хандлага
- к. Багаар ажиллах чадвар
- л. Бусад (бичнэ үү)

30. Танай ААНБ сүүлийн 3 жилд үйлдвэрлэл, үйлчилгээний ажилд МСҮТ, политехник коллеж төгсөгчдөөс ажилд авсан уу?

а. Тийм б. Үгүй

31. Хэрвээ “тийм” бол ямар мэргэжлээр, аль сургуулиас, хэдэн төгсөгчийг ажилд авсан бэ?

№	Мэргэжил	Индекс	Аль сургуулиас	Ажилд авсан хүний тоо	Үүнээс: Эмэгтэй
1					
2					
3					
4					

32. МСҮТ, политехник коллеж төгсөгчдийн мэдлэг, чадварын талаарх дараах үнэлгээтэй Та хэр зэрэг санал нийлэх вэ? (Санал огт нийлэхгүй-0, санал нийлэхгүй-1, мэдэхгүй-2, санал ерөнхийдөө нийлнэ-3, санал бүрэн нийлж байна-4 гэж хариултын ард бич)

Төгсөгчдийн онолын мэдлэг сайн	
Төгсөгчдийн практик ур чадвар өндөр	
Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх чадвар өндөр (багаар ажиллах, харилцааны соёл, ажлын хариуцлага, ёс зүй гэх мэт)	
Төгсөгчид ажлын өндөр ачаалалтай ажиллаж чаддаг	
Төгсөгчид багаар ажиллах чадвартай	
Төгсөгчид байгууллага, түүний өмч хөрөнгөнд өөриймсөг ханддаг	
Төгсөгчид суралцах, хөгжих эрмэлзэлтэй	
Төгсөгчдийн ажлын гүйцэтгэл, чанар өндөр байдаг	

33. Танай ААНБ нь МСҮТ, политехник коллеж, их, дээд сургууль төгсөгчийг ажилд аваад нэмэлт сургалтад хамруулдаг уу?

а. Тийм б. Үгүй

34. Хэрвээ “тийм” бол төгсөгчдөд нэмэлт сургалтаар ямар ур чадвар эзэмшүүлдэг вэ? (Бичнэ үү)

1.
2.
3.

35. Танай ААНБ-д анх ажилд орсон дараах ангиллын хүмүүсийн сарын үндсэн цалингийн хэмжээ дараах хүснэгтэд дурьдсан үндсэн цалингийн шатлалын алинд нь хамрагддаг вэ? (420 001-500 000 бол 1, 500 001-75 001 бол 2, 1 000 001-1 500 000 бол 3, 1 500 001-2 000 000 бол 4, 2 000 001-ээс дээш бол 5 гэж бич)

Инженер-техникийн ажилтан	
Албан хаагч	
Үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжлийн ажилтан	
Туслах үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжлийн ажилтан	
Түр ба улирлын ажилтан	
Мэргэжил, боловсрол шаардахгүй энгийн ажил	

36. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай дараах чиглэлээр хамтран ажиллаж байсан уу? (Тийм бол 1, Үгүй бол 0)

Үйлдвэртээ төгсөгчдийг авч ажиллуулах	
Ажилтнуудынхаа мэргэшлийн зэрэг ахиулах	
Сургуульд хичээл заах, шалгалт авахад инженерүүдээ оролцуулах	
Төгсөгчдийн мэргэжлийн ур чадварын талаар зөвлөлдөх	
Тодорхой нэг сургалт, курс, дамжааг ивээн тэтгэх	
Оюутан, суралцагчдыг үйлдвэртэйгээ танилцуулах, үйлдвэрлэлийн дадлага хийлгэх	

Үйлдвэрийн нэр дээр суралцуулах гэрээ байгуулах, оюутан, сурагчдын сургалтын зардлыг төлөх, ажилтнаа хамтран бэлтгэх	
Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд сар бүр санхүүгийн дэмжлэг, хандив өгөх	
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш нарыг үйлдвэр дээрээ дадлагажуулах	
Мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөр, бусад баримт бичиг хамтран боловсруулах	

37. Танай ААНБ Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай ямар чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой байна вэ?

1.
2.
3.
4.

38. Танай ААНБ үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад юу шаардлагатай байна вэ? (Хамгийн чухал гэсэн гурван зүйлүүдээ тэмдэглэнэ үү)

- а. Бага хүүтэй зээл
- б. Үйлдвэрлэлийн байр
- в. Мэргэжил, ур чадвартай ажилтны нийлүүлэлт
- г. Борлуулалтад үзүүлэх дэмжлэг
- д. Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт
- е. Төрийн худалдан авалтаар дэмжих
- ж. Ажлын шинэ байр бий болгосны дэмжлэг
- и. Тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ, дэмжлэг
- к. Худалдан авалтын сонгон шалгаруулалтыг ил тод, шударга болгох
- л. Бусад (нэрлэж бичнэ үү)

БИДНИЙ АЖИЛД ГҮН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛСЭН ТАНД БАЯРЛАЛАА!

**ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДЭЭС
АВАХ САНАЛ АСУУЛГА**

Та судалгаанд хамрагдсанаар Дорноговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлоход хувь нэмрээ оруулах болно.

1. Сум

2. Таны нас:

3. Таны хүйс: а. Эр б. Эм

4. Та ямар боловсролтой вэ?

- а. Доктор
- б. Магистр
- в. Бакалавр
- г. Техникийн буюу тусгай дунд
- д. Мэргэжлийн
- е. Бүрэн дунд
- ж. Суурь
- з. Бага
- и. Боловсролгүй

5. Та ямар мэргэжилтэй вэ?

№	Мэргэжил	Индекс
1		
2		

6. Таны үйл ажиллагаа аль салбарт хамаарах вэ?

1. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур
2. Уул уурхай, олборлолт
3. Боловсруулах үйлдвэрлэл
4. Цахилгаан, хий, уур, агааржуулалт
5. Усан хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа
6. Барилга
7. Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ
8. Тээвэр, агуулахын үйл ажиллагаа
9. Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ
10. Мэдээлэл, холбоо
11. Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа
12. Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа
13. Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа
14. Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа
15. Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал
16. Боловсрол
17. Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа
18. Урлаг, үзвэр, тоглоом наадам
19. Үйлчилгээний бусад үйл ажиллагаа
20. Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, хэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ
21. Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа

7. Та ямар төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг вэ? .

.....
.....
.....

8. Та энэ үйл ажиллагаагаа ямар хугацаанд эрхэлж байна вэ?

- а. 1 жил хүртэл
- б. 2-3 жил
- в. 4-5 жил
- г. 5-с дээш

9. Та үйл ажиллагаагаа ямар санхүүгийн эх үүсвэрээр эрхлэн явуулдаг вэ?

- а. Төсөл хөтөлбөрт хамрагдсан
- б. Банкны зээлээр
- в. Өөрийн хөрөнгөөр
- г. Бусад эх үүсвэр

10. Та өөрийн эзэмшлийн ажлын байртай эсэх

- а. Тийм
- б. Үгүй

11. Үйл ажиллагаагаа тогтвортой явуулахын тулд танд юу шаардлагатай байна? (Хамгийн чухлаас нь эхлэн эрэмбэлнэ үү)

Зээл	
Ажлын байр	
Мэргэжилтэй ажилтан	
Ажлын байран дээрх сургалт	
Туршлага судлах	
Бусад (бичих)	

12. Таны (өрхийн) үйлдвэрлэлд цалин хөлсгүй оролцогчийн тоо: (асуулгад хариулах үед) хүн, үүнээс эмэгтэй.

Насаар нь ангилбал:

15-19 настай	20-24 настай	25-29 настай	30-34 настай	35-39 настай	40-44 настай	45-49 настай	50-54 настай	55-59 настай	60 +	Нийт

13. Та ажилтан авч ажиллуулдаг уу?

- а. Тийм б. Үгүй (18-р асуулт руу шилжинэ үү)

14. Ажиллагсдын тоо

- а. 1 б. 2-3 в. 4-5 г. 6-10 д. 10-с дээш

15. Танай ажиллагсдын дундаж цалин хэд вэ?

- а. 4200 00 хүртэл в. 500 000-800 000
б. 420 000-500 000 г. 800 000-с дээш

16. Танай ажиллагсад нийгмийн даатгалын шимтгэл төлдөг үү?

- а. Тийм б. Үгүй

17. Хэрэв нийгмийн даатгалын шимтгэл төлдөг бол ямар хэлбэрээр төлдөг вэ?

- а. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр в. Ажилтантай тохиролцсоны дагуу
б. Сайн дурын хэлбэрээр

18. Танайд ажиллаж байгаад ажлаас гарсан ажилтан байгаа юу?

- а. Тийм б. Үгүй

19. Хэрвээ “тийм” бол ямар шалтгаанаар гарсан бэ?

- а. Өөрийн хүсэлтээр в. Мэргэжлийн ур чадвар хангалтгүй
б. Алдаа дутагдал гаргасан г. Эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй
д. Бусад /бичнэ үү/

20. Ажилтнуудаа тогтвор сууршилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн тулд та ямар ажил хийсэн бэ?

- а. Нийгмийн асуудлыг шийдсэн
б. Цалин, урамшууллыг нэмсэн
в. Мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх сургалтанд хамруулсан
г. Одоогоор ямар ч ажил хийж амжаагүй

21. Та цаашид ААН болж өргөжих сонирхолтой байна уу?

- а. Тийм б. Үгүй

22. Тийм бол аль хэлбэрээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх вэ?

- а. Нөхөрлөл б. Хоршоо в. ХХК

23. Үгүй бол ямар шалтгааны улмаас ААН болон өргөжих сонирхолгүй байна вэ?

- а. ААН болох талаар мэдлэг дутуу
б. Төрийн байгууллагын дарамт (татвар г.м)
в. Санхүүгийн тайлан гаргахад төвөгтэй байдаг
г. Хувиараа хөдөлмөр эрхлэх нь хялбар байдаг

24. Та цаашид ажилтан авч ажиллуулах бодолтой байна уу?

- а. Тийм б. Үгүй (26-р асуулт руу шилжинэ үү)

25. Танайх ойрын 3 жилд нэмж авах ажилтны тоог мэргэжлээр харуулна уу?

№	Мэргэжил	Индекс	Ажилтны тоо		
			2021	2022	2023
1					
2					
3					
4					
5					

26. Танайх ажилтан авахад ямар бэрхшээл тулгардаг вэ?

- | | |
|------------------------------------|--|
| а. Мэргэжлийн хүн олоходгүй | г. Нийтэч өөриймсөг байдал үгүйлэгддэг |
| б. Мэргэжлийн ур чадвар хангалтгүй | д. Ажлын цаг баримталдаггүй |
| в. Мэргэжлийн ур чадвар дутмаг | е. Бусад |

27. Та ажилтан авахдаа дараах ур чадваруудаас алийг нь голлон хардаг вэ?

(нэгээс олон хариулт байж болно)

- | | |
|--------------------------|--------------------------------------|
| а. Ажлын ачаалал даах | в. Ажилд хариуцлагатай хандах чадвар |
| б. Багаар ажиллах чадвар | г. Харилцааны ур чадвар |

28. Шинээр ажилтан авахдаа мэдээллийн ямар эх үүсвэр ашигладаг вэ?

- | | |
|---|---|
| а. Хүмүүс өөрсдөө ханддаг | г. Бусдын аман мэдээллээр |
| б. Сонины болон ТВ зараар | д. Интернетээс |
| в. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | е. Зуучлалын байгууллагуудаар дамжуулан |

БИДНИЙ АЖИЛД ГҮН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛСЭН ТАНД БАЯРЛАЛАА!

**МАЛЧИН ӨРХӨӨС АВАХ САНАЛ
АСУУЛГА**

Та судалгаанд хамрагдсанаар Дорноговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлоход хувь нэмрээ оруулах болно.

1. Сум:

2. Өрхийн тэргүүлэгчийн нас:

- а. 15-19 г. 30-34 ё. 45-49 и. 60 ба дээш
б. 20-24 д. 35-39 ж. 50-54
в. 25-29 е. 40-44 з. 55-59

3. Өрхийн тэргүүлэгчийн боловсрол:

- а. Доктор г. Техникийн буюу тусгай дунд ж. Суурь
б. Магистр д. Мэргэжлийн з. Бага
в. Бакалавр е. Бүрэн дунд и. Боловсролгүй

4. Танай малын тоо:

- а. 100 хүртэл в. 201-500 д. 1000-ээс дээш
б. 101-200 г. 501-1000

5. Таны (өрхийн) мал аж ахуйн үйлдвэрлэлд цалин хөлсгүй оролцогчийн тоог бичнэ үү.

15-19 насны	20-24 насны	25-29 насны	30-34 насны	35-39 насны	40-44 насны	45-49 насны	50-54 насны	55-59 насны	60 +	Нийт

6. Танай өрхөд ямар хэрэгцээ байна вэ?

- а. Малжуулах арга хэмжээ в. Туслах малчин авах
б. Сургалт г. Туршлага судлах

7. Хэрэв та б хувилбарыг сонгосон бол аль сургалтыг сонирхож байна вэ?

- а. Мал маллах арга ухааны сургалт
б. Малаас гарах түүхий эд боловсруулах
в. Мэргэжил олгох сургалт (бичих)
г. Өрхийн эдийн засгийн сургалт

8. Та туслах малчинтай юу?

- а. Тийм б. Үгүй (асуулт 11-рүү шилжинэ)

9. Хэрвээ та туслах малчинтай бол ямар гэрээ байгуулсан бэ?

- а. Гэрээ байгуулаагүй, аман тохиролцоогоор в. Хөдөлмөрийн гэрээ байгуулсан
б. Бичгэн гэрээ байгуулсан

10. Та туслах малчнаа ямар хэлбэрээр цалинжуулдаг вэ?

- а. Бэлэн мөнгөөр б. Мөнгөн бус хэлбэрээр в. Малаар

11. Та туслах малчнаа ямар сургалтад хамруулах вэ?

- а. Мэргэжил олгох б. Шавь сургалт в. Бусад (бичнэ үү)

12. Та ойрын 3 жилд туслах малчин шинээр авах бол хэзээ, хэдэн малчин авах вэ?

	2021 онд	2022 онд	2023 онд
Туслах малчны тоо			

13. Туслах малчинд ямар шалгуур тавих вэ?

1.
2.

14. Та болон туслах малчин нийгмийн даатгалд хамрагдсан уу?

- а. Зөвхөн өөрөө хамрагдсан б. Хоёулаа хамрагдсан в. Хоёулаа үгүй

15. Та аль нэг хүүхдээ удам дамжсан малчин болгох сонирхолтой байна уу?

- а. Тийм б. Үгүй

БИДНИЙ АЖИЛД ГҮН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛСЭН ТАНД БАЯРЛАЛАА!

**АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АВАХ САНАЛ
АСУУЛГА**

Та судалгаанд хамрагдсанаар Дорноговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлоход хувь нэмрээ оруулах болно.

1. Таны нас:

- а. 15-19 г. 30-34 ё. 45-49 и. 60 ба дээш
 б. 20-24 д. 35-39 ж. 50-54
 в. 25-29 е. 40-44 з. 55-59

2. Таны хүйс:

- а. Эрэгтэй б. Эмэгтэй

3. Та ямар боловсролтой вэ?

- а. Доктор г. Техникийн буюу тусгай дунд ж. Суурь
 б. Магистр д. Мэргэжлийн з. Бага
 в. Бакалавр е. Бүрэн дунд и. Боловсролгүй

4. Та мэргэжилтэй юу?

- а. Тийм б. Үгүй (7 дугаар асуулт руу шилжинэ үү)

5. Тийм бол та ямар мэргэжилтэй вэ?

№	Мэргэжил	Индекс
1		
2		

6. Та эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байсан уу?

- а. Тийм б. Үгүй

7. Таны ажил, хөдөлмөр эрхлэхгүй байгаа гол шалтгаан юу вэ?

- а. Мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа
 б. Мэдлэг ур чадвараар тэнцэхгүй байгаа
 в. Ажил олгогчийн тавьсан шаардлагад тэнцэхгүй байгаа
 г. Ажиллах нөхцөл хүнд учраас
 д. 40-с дээш настай тул ажилд авдаггүй
 е. Эрүүл мэндийн шалтгаанаас
 ж. Цалин бага учраас
 з. Ажилдаа сонирхолгүй учир
 и. Ажиллахыг хүссэн байгууллага биш
 к. Гэрээсээ хол явж ажиллах сонирхолгүй
 л. Түр хугацааны ажил хийж боломжийн орлого олдог учир
 м. Ажил хийхийг хүсдэггүй
 н. Ар гэрийн байдал болон өвчтэй хүн, хүүхэд асардаг
 о. Бусад

8. Ямар хугацаанд ажил хөдөлмөр эрхлэхгүй байна вэ?

- а. 1-6 сар б. 6-12 сар в. 12-24 сар г. 24 сараас дээш

9. Та ажил хайгчаар бүртгүүлсэн үү?

- а. Бүртгүүлсэн б. Бүртгүүлээгүй, энэ тухай хаана хандахаа мэдэхгүй
 в. Бүртгүүлээгүй, бүртгүүлсэн ч ажил олдохгүй гэж боддог

10. Та өмнө нь ямар нэгэн байгууллагад ажиллаж байсан уу?

- а. Тийм б. Үгүй

11. Хэрвээ “тийм” бол та ямар байгууллагад ажиллаж байсан бэ?

№	ААНБ-ын хариуцлагын хэлбэр	Ямар мэргэжлийн ажил эрхэлж байсан
1	Төсвийн байгууллага	
2	Хувьцаат компани	
3	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	
4	Төрийн өмчит үйлдвэрийн газар	
5	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	
6	Хоршоо	
7	Нөхөрлөл	
8	Төрийн бус байгууллага	
9	Бусад	

12. Өмнөх ажлаасаа гарсан шалтгаан, үндэслэл юу байсан бэ?

- а. Цомхотголд орсон
- б. Байгууллага татан буугдсан, дампуурсан
- в. Хувийн шалтгаан байсан тул өөрийн санаачилгаар халагдсан
- г. Ажил олгогчийн санаачилгаар халагдсан
- д. Ажил олгогчтой харилцан тохирсон
- е. Хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж цаашид сунгагдаагүй
- ж. Хугацаат цэргийн албанд татагдсан
- з. Цалин бага байсан
- и. Жирэмсэн, амаржсан, хүүхэд асрах чөлөөтэй байсан ажилтны оронд ажиллаж байсан
- к. Ажиллах нөхцөл хүнд, хортой байсан
- л. Мэргэшил, ур чадвар хүрэлцэхгүй байсан
- м. Бусад (бичнэ үү).....

13. Танд цаашид ямар хэрэгцээ байна вэ?

- а. Мэргэжлийн зэргээ ахиулах
- б. Мэргэжил эзэмших
- в. Мэргэжлийнхээ ажилд орох
- г. Хувиараа хөдөлмөр эрхлэх
- д. Зээлд хамрагдах
- е. Ямар ч хамаагүй ажилд орох
- ж. Зөвлөгөө, мэдээлэл авах
- з. Сургалтад хамрагдах
- и. Бусад (бичих)

14. Та ажил хөдөлмөр эрхлэхийн тулд суралцах сонирхолтой байна уу?

- а. Тийм
- б. Үгүй

15. Хэрвээ “тийм” бол ямар мэргэжлээр суралцах сонирхолтой байна вэ?

№	Мэргэжил	Индекс
1		
2		

16. Хэрвээ суралцах бол ямар түвшний сургалтанд хамрагдах вэ?

- а. Доктор
- б. Магистр
- в. Бакалавр
- г. Техникийн боловсрол
- д. Мэргэжлийн боловсрол
- е. Мэргэжлийн богино хугацааны сургалт
- ж. Давтан сургалт

17. Та хаана ажиллах сонирхолтой байна вэ?

- а. Төрийн байгууллагад
- б. Аж ахуй нэгжид
- в. Хувиараа хөдөлмөр эрхлэх
- г. Аж ахуй нэгж үүсгэн байгуулах
- д. Бусад

БИДНИЙ АЖИЛД ГҮН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛСЭН ТАНД БАЯРЛАЛАА!

**АЖИЛЛАЖ БАЙГАА ЗАЛУУЧУУДААС
АВАХ САНАЛ АСУУЛГА**

Та судалгаанд хамрагдсанаар Дорноговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлоход хувь нэмрээ оруулах болно.

1. Таны хүйс:

- а. Эрэгтэй б. Эмэгтэй

2. Нас:

- а. 15-19 б. 20-24 в. 25-29 г. 30-34 д. 35-39

3. Таны ажиллаж буй ААНБ, албан тушаалын нэр: _____

4. Та ямар боловсролтой вэ?

- а. Доктор г. Техникийн буюу тусгай дунд ж. Суурь
б. Магистр д. Мэргэжлийн з. Бага
в. Бакалавр е. Бүрэн дунд и. Боловсролгүй

5. Та ямар мэргэжил эзэмшсэн бэ?

Мэргэжил	Индекс	Боловсролын түвшин	Төгссөн он

6. Мэргэжлээ сонгоход нөлөөлсөн хүчин зүйлийг хамгийн чухлаас нь эхлэн эрэмбэлнэ үү.

Мэргэжлээрээ ажиллахад авах цалин хөлс	
Мэргэжлийн нэр хүнд өндөр	
Тухай мэргэжлийг их сурталчилж байсан	
Төгсөөд шууд ажиллах боломжтой	
Элсэхэд хялбар, босго оноо доогуур байсан	
Гэр бүлийн уламжлалын дагуу сонгосон	
Төгсөөд төрийн байгууллагад ажиллана	
Эрэлт ихтэй мэргэжлүүдийн тухай мэдээлэлтэй байсан	
Ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө авсан	
Найз нөхдөөсөө зөвлөгөө авсан	
Суралцах үед олгох тэтгэлэг, тэтгэмж	
Бусад (бичих)	

7. Та мэргэжлээрээ ажиллаж байна уу?

- а. Тийм б. Үгүй

8. Таны эрхэлж буй ажлын байрны төрөл:

- а. Байнгын байр б. Улирлын ажлын байр в. Түр ажлын байр

9. Таны сарын цалин:

- а. 420 000 хүртэл б. 420 001-600 000 в. 600 001-1000 000 г. 1000 000-аас дээш

10. Та одоогийн эрхэлж буй ажлын хажуугаар ямар нэгэн хувийн бизнес, аж ахуй эрхэлдэг үү?

- а. Тийм б. Үгүй

11. Хэрэв мэргэжлээрээ ажиллахгүй байгаа бол шалтгаан?

- а. Мэргэжилд тохирох ажил олдохгүй
б. Мэдлэг ур чадвараар тэнцэхгүй
в. Ажил олгогчийн тавьсан шаардлагад тэнцэхгүй
г. Эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй
д. Цалин бага
ж. Бусад

12. Таны суралцаж төгссөн сургууль (МСҮТ, коллеж, их, дээд сургууль гэх зэрэг)-д Та ямар ур чадвар, хандлага эзэмшиж чадаагүй гэж үздэг вэ? (Хэд хэдийг бөглөж болно)

- а. Багаар ажиллах чадвар
б. Хариуцлага хүлээх, ил тод байдлыг хангаж тайлагнах
в..Байнга суралцах, мэргэших хандлага

- г. Харилцааны чадвар
- д. Маргаан шийдвэрлэх чадвар
- е. Ажлыг системтэй гүйцэтгэх чадвар
- ж. Бусад (тодорхой бичнэ үү)

13. Та ажиллах боломжоо нэмэгдүүлэхийн тулд шинэ боловсрол, мэргэжил эзэмших шаардлагатай юу?

- а. Тийм
- б. Үгүй

14. Хэрэв тийм бол суралцах мэргэжлийг бичнэ үү?

.....

15. Таны хувьд ажиллах ямар нөхцөл хамгийн чухал вэ? Хамгийн чухлаас нь эхлэн эрэмбэлнэ үү.

Өндөр цалин хөлс	
Албаны унаа, гар утас	
Эрүүл мэндийн даатгал	
Сургалт	
Хоол, унааны зардлын хөнгөлөлт	
Өндөр шагнал	
Хүүхдийн цэцэрлэг, яслийн төлбөр төлөхөд туслалцаа үзүүлэх	
Өндөр насны нэмэлт тэтгэврийн тогтолцоо	
Орон сууцаар хангах	
Нэмэгдэл амралт	
Бусад (бичих)	

МАНАЙ СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТАНД ИХ БАЯРЛАЛАА!

